# "Монгол улсын Засгийн газраас ХДХВ/ДОХ/БЗДХ-ын тархалтаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, цаашид анхаарах асуудал"

# Монгол улсад бүртгэгдсэн ХДХВ-ийн халдварын тохиолдол, нас баралтын тоо өссөн дүнгээр

(1992–2013 оны 11 сарын 25-ны байдлаар)



# ХДХВ-ийн халдвар дэлхий дахинд




*Global Report /UNAIDS/*

**Монгол дахь өнөөгийн байдал:**

Нийт хүн амын дунд < 0.1%

Эрсдэлт бүлгийн хүн амын дунд – 7.5% (SGS 2011)

2011 оны Тооцооллоор – ХДХВ-ийн халдвартай 674 хүн*

**Spectrum/EPP 4.47 2011 он*

# Монгол дахь ХДХВ/ДОХ-ын халдвар тээгчдийн хүйсийн байдал



# Зонхилон тохиолдох БЗДХ, 10000 хүн амд (1993-2012 он )




Сүүлийн жилүүдэд БЗДХ-ын өвчлөл нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. 2012 онд зонхилон тохиолдох БЗДХ-ын нийт 14490 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оныхоос 1046 тохиолдлоор ихэссэн байна. Ялангуяа тэмбүү өвчин 10000 хүн амд 17.8 байгаа нь өнгөрсөн оныхоос 2.5 промилиэр ихэссэн үзүүлэлттэй байна

# 2012 онд бүртгэгдсэн халдварт өвчний бүтэц




2012 онд улсын хэмжээнд 25 төрлийн 43305 халдварт өвчин бүртгэгдсэн. Нийт халдварт өвчний 33.5%-ийг БЗДХ-ын зонхилон тохиолдох 3 өвчний өвчлөл эзэлж байна.

# Улсын хэмжээнд бүртгэгдсэн Төрөлхийн тэмбүүгийн тохиолдол




Сүүлийн 3 жилийн байдлаар төрөлхийн тэмбүүгийн тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд өнгөрсөн 2012 онд нийт 25 тохиолдол, Дорноговь аймагт 3, Орхон аймагт 4, Өвөрхангай аймагт 1, Увс аймагт 1, Хэнтий аймагт 1, Улаанбаатар хотод 15 тохиолдол бүртгэгдсэн.

# Үндэсний хэмжээнд мөрдөгдөж буй бодлогын бичиг баримт

1. “ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай хууль” 2012 оны 12 сард УИХ-аар батлагдсан.
2. “ХДХВ/ДОХ,БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө /2010-2015/” ЗГ-ын 2010 оны 43-р тогтоолоор батлагдсан.
3. “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2011-2015/-г ЗГ-ын 2011 оны 108-р тогтоолоор батласан.
4. “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний удирдамж” ЭМС-ын 2009 оны 429 тоот тушаалаар батлагдсан. Эрүүл мэндийн байгууллагын бүхий л түвшинд БЗДХ/ХДХВ/ДОХ-ын оношлогоо, эмчилгээ, тусламж үйлчилгээ энэ удирдамжийг мөрдөж ажиллаж байна.
5. “ХДХВ-ийн халдвар илрүүлэх Сайн Дурын Зөвлөгөө Шинжилгээний төвийн дүрэм үйл ажиллагааны удирдамж” ЭМС- ын 2011 оны 427 тоот тушаалаар батлагдсан.
6. “Төрөлхийн тэмбүү өвчнөөс сэргийлэх үндэсний стратеги /2011-2015/” ЭМС-ын 2010 оны 458 тоот тушаалаар батлагдсан.
7. “Жирэмсэн эмэгтэйн тэмбүү өвчнийг эрт оношлож эмчлэх журам”- ЭМС-ын 2011 оны 350 тоот тушаалаар батлагдсан.., гэх мэт

# ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагааны хяналт, шинжилгээ үнэлгээ

1. ХДХВ/БЗДХ-ын Тандалт Судалгаа – 2002 оноос хойш 2 жил тутамд, SGS
2. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа
3. Хүүхэд Хөгжил судалгаа, MICS
4. “ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний ахиц дэвшлийн тайлан” UNGASS
5. “Бүх нийтэд ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх”, Universal Access.., гэх мэт

# “ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө (2010-2015)”-ний дунд хугацааны хөндлөнгийн үнэлгээ






# “ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тусламж үйлчилгээний үндэсний хариу арга хэмжээний санхүүгийн зарцуулалтын үнэлгээ (2010-2011)”

ХДХВ/ДОХ-ын үндэсний зарцуулалт:

- 2010 онд 5,243,014,112.62₮
- 2011 онд 5,332,226,581.48₮



# Цаашид анхаарах асуудлууд

- ХДХВ/ДОХ-той тэмцэх илүү үр ашигтай, шинэлэг, тогтвортой хөтөлбөрүүдийг үндэсний хөгжлийн төлөвлөгөө, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зорилтот хүн амд чиглүүлж урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнг сайжруулах
- ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх бүхий л үйл ажиллагааг эрчимжүүлэн, олон салбарын оролцоог хангаж, уялдаа холбоог сайжруулах
- Санхүүгийн тодорхой, тогтвортой эх үүсвэр бүрдүүлж, хөрөнгө санхүүжилтыг үе шаттайгаар нэмэгдүүлэх

# Анхаарлаа хандуулсанд баярлалаа